



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 160

Улаанбаатар хот

Ц.Содномдамбатай байгуулсан
контрактын тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1, 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, захиралтай байгуулсан контрактын 5.2.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2018 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин батлагдаагүй тул “Төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит компанийн захиралтай контракт байгуулах, дүгнэх журам”-ын дагуу Ц.Содномдамбатай байгуулсан контрактын биелэлтийг дүгнэх боломжгүй гэж үзсүгэй.

2. “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Цэрэндоржийн Содномдамбыг өөрийнх нь хүсэлтээр захирлын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

3. Ц.Содномдамбын ээлжийн амралтын болон холбогдох бусад тооцоог хийж, ажлыг 2019 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохих журмын дагуу хүлээлцүүлэхийг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хууль зүйн хэлтэс (А.Ариунболд)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД